



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД

14200 Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг
Бага тогируу 44 Засгийн газрын III багц
Утас 26-24-80 Факс (976-31) 32-31-58
E-mail info@mecs.gov.mn http://www.mecs.gov.mn

2018. 02. 15 № 7а / 1525

танай _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ж.БАТЗАНДАН ТАНАА

Таны "Асуулга тавих тухай" 2018 оны 03 тоот
албан тоотоор ирүүлсэн асуулгатай танилцлаа.

Асуулгын хариуг холбогдох мэдээллийн хамт
хавсралтаар хүргүүлж байна.

Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт,

Хавсралт ... хуудастай.



ЛОГЗОЛМАА

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайдын 2018 оны 02 дугаар сарын 15-ны
өдрийн 1.4/1.58 Тоот албан бичгийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ж.БАТЗАНДАНГИЙН АСУУЛГЫН ХАРИУ

Монгол Улсад 2018 оны 1 дүгээр сарын байдлаар төрийн өмчийн 12, орон нутгийн өмчийн 24 музей байнгын болон түр үзэсгэлэнгийн танхимаар үзэгчдэд үйлчилж тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Мөн Монголбанк, Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Иргэний нисэхийн ерөнхий газар зэрэг төрийн байгууллага, Шинжлэх Ухааны Академийн Түүх, археологийн хүрээлэн, Палеонтологи, геологийн хүрээлэн зэрэг эрдэм шинжилгээний байгууллага, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Улаанбаатарын их сургууль "Их Засаг" олон улсын их сургууль зэрэг их, дээд сургуулийн дэргэд 16 бэсрэг музей, үзвэрийн танхим ажиллаж байна.

Түүнчлэн, Олон улсын оюун ухааны музей, "Данзанравжаа" музей, Монголын Уламжлалт Анагаах Ухааны Музей, Чингис хааны өв соёлын музей, Хэлмэгдэгсдийн дурсгалын музей, Монгол костюмс музей, Цагаандариум музей, галерей зэрэг тогтмол үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн 8 музей байна.

2017 оны гүйцэтгэлээр төрийн болон орон нутгийн өмчийн 36 музей нь улс, орон нутгийн төсвөөс 7.317.643.500 төгрөгийн санхүүжилт авч, давхардсан тоогоор 500.000 орчим хүнд үйлчилж 1.650.606.129 төгрөгийн орлогыг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ. Эдгээр музейд 630 гаруй ажилтан албан хаагчид ажиллаж байна.

1. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан Соёлын өвийг бүртгэх журмын хэрэгжилтийн байдал, тус хуулийн 26 дугаар зүйлд заасан Соёлын өвийн улсын тооллогын мэдээллийн тухайд 2016-2017 онд хийгдэх байсан улсын тооллого яагаад хугацаандаа зохион байгуулагдаагүй, "2012 оны улс, орон нутгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогын нэгдсэн дүн"-д ямар арга хэмжээ авсан тухайд;

Соёлын өвийг бүртгэл, мэдээллийн санд бүртгэх, мэдээллийг баяжуулах, тоон мэдээллийг баримтжуулж шинэчлэх ажлыг Соёлын өвийн үндэсний төв тасралтгүй хэрэгжүүлж байна. 2017 онд тус төвийн мэргэжилтнүүд Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад орсон 212 дурсгалт зүйлийг дүрс бичлэгээр баримтжуулан, 11 дурсгалт зүйлийг тоон мэдээллийг 3D сканнер ашиглан цуглуулж боловсруулалт хийн мэдээллийг баяжуулсан болно. Мөн хууль хяналтын холбогдох

байгууллага (цагдаа, тагнуул, гаалийн байгууллага)-д хураагдаж, шүүхийн шийдвэрээр төрийн өмчлөлд шилжүүлсэн 282 ширхэг түүх, соёлын дурсгалт зүйлийн бүртгэлийг шинээр үйлдэж хадгалсан байна.

2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тус төвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд төрийн болон орон нутгийн өмчийн 36 музейгээс гадна Монголбанкны Эрдэнэсийн сан, Монгол Улсын Үндэсний номын сангийн Үнэт ховор номын музей, Төвхөн хийд, Шанхын Баруун хүрээ хийд, Гандантэгчинлэн хийд, "Данзанравжаа" музей, мөн 20 аймгийн 257 сумын орон нутаг судлах музей, үзвэрийн танхим, 1 дүүргийн орон нутгийн музейд хадгалагдаж байгаа 129.983 дэсийн 315.955 ширхэг түүх, соёлын дурсгалт зүйлийн бүртгэл, соёлын биет бус өвийн 6700 гаруй өвлөн уламжлагчийн бүртгэл, түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 9537 дурсгалт газрын 86157 ширхэг дурсгалын бүртгэл холбогдох гэрэл зураг, дүрс бичлэг, бусад мэдээллийн хамт цаасан болон цахим суурьтайгаар хадгалагдаж байна.

Цаашид соёлын өвийн мэдээллийг боловсруулж чанаржуулах, бүрэн гүйцэд бүрдүүлэх, соёлын биет өвийг хадгалж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг хүлээн авч хадгалах талаар шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

б) Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлэх зорилгоор түүх, соёлын дурсгалт зүйлийн үзлэг, тооллого явуулахаар тус яамнаас 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ч үзлэг, тооллого явуулах журамд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх шаардлага үүссэн, мөн үзлэг, тооллоготой холбоотой бэлтгэлийг хангахад шаардагдах төсөв, хөрөнгийн хүрэлцээгүй байдлын улмаас төлөвлөгөөт үзлэг, тооллогыг явуулж чадаагүй болно. Үзлэг, тооллогын ажлын бэлтгэлийг ханган 2018 онд явуулахаар ажиллаж байна.

в) Улс, орон нутгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогын ажлыг 2012 оны 08 дугаар сарын 15-ны өдөр эхлүүлж, дүн мэдээг 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн Засгийн газрын ээлжит хуралдаанд танилцуулжээ. Засгийн газраас "Улс, орон нутгийн сан хөмрөгийн улсын тооллогын дүнгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай" 197 дугаар тогтоол баталж, музейн хүрээнд тулгамдсан зарим асуудлыг шийдвэрлэхийг холбогдох сайд нарт даалгажээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам /хуучин нэрээр/-наас Засгийн газрын 197 дугаар тогтоолын 1.1-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор Музейн тухай хуулийн төслийг боловсруулж үзэл баримтлалыг, 2015 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Хууль зүйн сайдаар батлуулсан байна. Тус яам Музейн тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хурлын хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.

Тогтоолын 1.2-т заасан Монголын Үндэсний музей, Дүрслэх урлагийн музей, Богд хааны ордон музей, Чойжин ламын сүм музей, Эрдэнэ Зуу музейг цагдаагийн хамгаалалтад авах онц чухал объектийн жагсаалтад оруулах талаар Засгийн газрын 2017 оны 281 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын шийдвэрийн төслийг боловсруулан ажиллаж байна. Тогтоолын 1.3-т улс, орон нутгийн музейг зориулалтын барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжөөр хангах, засвар үйлчилгээнд шаардагдах зардлыг үе шаттайгаар жил бүрийн төсөвт тусгахаар заажээ. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам дээрх асуудалд онцгой анхаарч, Засгийн газрын 2016-2020 оны Засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 4 музейн барилгыг шинэчлэх, 10-аас доошгүй музейн сан хөмрөгийг стандартын шаардлагад нийцүүлэн засварлах зорилтыг тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2017 онд улсын төсвөөс музейн барилга байгууламжийн засварт 288.0 сая төгрөг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд 2017 оны 140.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Тогтоолын 1.4-т заасан түүх, соёлын дурсгалт зүйлийг тодорхойлох шинжээч, музейн нарийн мэргэжлийн ажилтнуудыг өндөр хөгжилтэй оронд бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх заалтын хүрээнд 2016, 2017 онд БНХАУ-д 11 мэргэжилтэн, БНСУ-д 2 мэргэжилтэн, Япон улсад 1 мэргэжилтэнг дунд хугацааны сургалтад хамруулан чадавхийг нь дээшлүүлсэн байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам 2018-2019 онд ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс, ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газартай хамтран соёлын биет өвийн чиглэлээр үндэсний шинжээч бэлтгэх сургалтыг 2 үе шаттай зохион байгуулахаар харилцан тохиролцож зохих бэлтгэлийг хангаж байна.

Тус яамнаас тогтоолын 1.5-д заасан “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам”-ын төслийг боловсруулан Сангийн яамтай хамтран батлахаар байна.

Тогтоолын 2 дахь хэсэгт заасан Эрдэнэ Зуу музей, Амарбаясгалант хийд, Балданбэрэйвэн хийд, Өөлд бэйсийн дуганууд, Эрдэнэдалайн дуганыг төрийн өмчлөлд шилжүүлэх асуудлаар холбогдох хууль тогтоомжид заасны дагуу аймаг орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газартай хамтран орон нутгийн өмчөөс үл хөдлөх хөрөнгө төрийн өмчид шилжүүлэх шийдвэрийн төслийг боловсруулан ажиллаж байна.

2. Түүх, соёлын хөдлөх зарим дурсгалт зүйлс хувь хүмүүсийн хууль бус эзэмшилд байгаа ба үзмэр, дурсгалт зүйлсийг эргүүлэн авах, нийтийн өмчийн соёлын биет өвд бүртгэх, сэргээн засварлах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашид хийгдэх ажлын тухай;

Тухайлбал, Монгол Улсаас Бүгд Найрамдах Унгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар ажиллаж байсан Т.Ганди нь 2015 оны 4 дүгээр сард манай улсын соёлын үнэт өв болох Өндөр Гэгээн Занабазарын бүтээсэн “Аюуш” бурханыг Монгол улсад хүлээлгэж өгсөн бөгөөд энэ бурханыг соёлын өвд бүртгэж авсан эсэх, одоо хаана хадгалагдаж байгаа тухай;

а) Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд 2018 оны 01 дүгээр сарын байдлаар төрийн болон орон нутгийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс хууль бусаар хувь хүний эзэмшилд байгаа тухай мэдээлэл байхгүй байна. Харин өмчлөгч, эзэмшигчийн зүгээс иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийг судалж үзээд холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, түр хугацаагаар эзэмшүүлж байгаа 232 дэсийн 429 ширхэг дурсгалт зүйл байна. Тухайлбал Монголын Үндэсний музейгээс Улс төрийн хэлмэгдэгсдийн музейд 180 дэсийн 237 ширхэг /барилгын засварын ажилтай уялдуулан түр хугацаанд эгүүлэн татаж Монголын Үндэсний музейн сан хөмрөгт хадгалж байгаа/, Эрдэнэ Зуу музейгээс Бат Эрдэнэзуу хийдэд 52 дэсийн 192 ширхэг, үзмэр, эд өлгийн зүйлсийг гэрээгээр эзэмшүүлж байна. Музейн зүгээс гэрээгээр эзэмшүүлсэн үзмэр, эд өлгийн зүйлсийн хадгалалт хамгаалалт, ашиглалтын нөхцөл байдалд байнгын хяналт тавьж, улсын болон байгууллагын тооллогод тухай бүр хамруулж байна.

б) Бүгд Найрамдах Унгар Улсын иргэн Ласло Кадараас Монгол Улсад хүлээлгэн өгсөн Өндөр Гэгээн Занабазарын бүтээсэн “Аюуш” бурханыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/244 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Дүрслэх урлагийн музейн сан хөмрөгт шилжүүлсэн байна. Уг бурхан соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд “1125 ДҮМ 03599” дугаар дээр бүртгэгдсэн болно. /Бурханыг соёлын өвийн бүртгэл мэдээллийн санд бүртгэсэн тухай холбогдох баримтыг хавсаргав/

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам “Аюуш” бурханы түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг харгалзан холбогдох тодорхойлолт, судалгааг бүрдүүлэн Засгийн газрын 2015 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” 390 дүгээр тогтоолоор Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад оруулсан байна.

3. Соёлын биет өвийг өмчлөгч иргэд, хуулийн этгээдүүд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т заасан үүргээ биелүүлж байгаа эсэх, тухайн иргэд, хувийн цуглуулагчид хадгалалт хамгаалалтын буюу стандартын шаардлага хангасан орчин, нөхцөл бүхий музей, галерей байгуулсан, зохих журам, шаардлагын дагуу үзмэрүүдээ хадгалж байгаа эсэх;

а) 2018 оны 01 дүгээр сарын байдлаар иргэдийн зүгээс өөрийн өмчлөлд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлсээ сум, дүүрэг, аймаг, нийслэлийн соёлын өвийн бүртгэл,

мэдээллийн санд бүртгүүлсэн тохиолдол байхгүй, харин Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд нийт 32 иргэн хандаж 61 дэсийн 63 ширхэг түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгүүлсэн байна.

б) Хувь иргэд, цуглуулагчид өөрийн өмчлөлд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах эд зүйлсээр музей, галерей байгуулан ажиллуулах явдал сүүлийн жилүүдэд цөөнгүй гарч байгаа ч өмчлөгчийн зүгээс тухайн эд зүйлсийг соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх санаачлага бага гаргаж байна. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд 2018 оны 1 дүгээр сарын байдлаар Соёлын гавъяат зүтгэлтэн З.Алтангэрэлийн үндэслэн байгуулсан Данзанравжаа музейд хадгалагдаж байгаа түүх, соёлын дурсгалт зүйлс бүртгээд байна, харин Соёлын гавъяат зүтгэлтэн З.Түмэн-Өлзийн үндэслэн байгуулсан Оюун ухааны олон улсын музей, Академич Д.Цэрэнсодномын үндэслэн байгуулсан Монголын Уламжлалт Анагаах Ухааны Музейн өмчлөгч нарт түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгэх арга зүйн заавар зөвлөгөө өгч, улсын бүртгэлд хамруулахаар ажиллаж байна.

Манай улсад хувийн музейн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчин бүрдээгүй, музейн салбарт мөрдөж байгаа Улс, орон нутгийн музейн дүрэм, Улс орон нутгийн музейн сан хөмрөгийн дүрэм, Музейн үйл ажиллагаанд тавигдах шаардлага MNS 5634:2006 стандартын үйлчлэх хүрээ зөвхөн улс, орон нутгийн музейгээр хязгаарлагдсан байдаг. Тус яамнаас шинээр боловсруулж байгаа Музейн тухай хуулийн төсөлд хувийн өмчийн музей эрхлэх асуудлыг олон улсын туршлага, өөрийн орны онцлогт үндэслэн цогц байдлаар тусгаж, эрх зүйн шинэ орчин бүрдүүлэхээр ажиллаж байна.

4. Хулгайд болон гадаад улс орнууд руу олон улсын үзэсгэлэнд илгээсэн нэрийдлээр алдагдсан, сэргээн засварлах боломжгүй байсан тул устаж үрэгдсэн гэх зэргээр алдагдсан тохиолдлууд, гэмт хэргийн болон зөрчлийн шинжтэй олон гэмт үйлдлүүдийг хууль хяналтын байгууллагууд хэрэг үүсгэн шалгаж байгаа эсэх, Хөвсгөл, Дархан-Уул, Архангай, Өмнөговь, Увс зэрэг аймгийн музей болон Өвөрхангайн Хархорины Шанхын хийдээс алдагдсан нэр бүхий үзмэрүүд олдсон эсэх, цагдаагийн байгууллага хэрэг үүсгэн шалгаж байгаа эсэх;

а) Төрийн болон орон нутгийн музейгээс хулгайд алдагдсан үзмэр, эд өлгийн зүйлийн мөрдөн шалгах ажиллагаа, шийдвэрлэсэн байдлын талаарх мэдээллийг 2008, 2012 оны улсын тооллогын дүн мэдээ болон 2018 оны 1 дүгээр сард музейгээс ирүүлсэн баримтад үндэслэн гаргалаа.

Архангай аймгийн музей:

- Аймгийн музейгээс 1997 онд Төгс баясгалант-Буяндэлгэрүүлэх хийдэд түр хугацаагаар шилжүүлсэн 34 ширхэг бурхан алга болсон гэх хэрэгт тус

аймгийн Цагдаагийн хэлтсээс эрүүгийн 901463 тоот хэрэг үүсгэн мөрдөн шалгажээ. Хэргийг аймгийн Прокурорын газрын хяналтын прокурорын 2004 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн “Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон тухай ” 28 дугаар тогтоолоор “хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан” гэх шалтгаанаар хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

- 2001 онд музейн сүмийн дээврийг эвдэн орж Ямандаг бурхан хулгайлсан хэрэгт аймгийн Цагдаагийн хэлтсээс эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгажээ. 2002 онд хэрэгт холбогдох этгээдийг баривчилж, тус аймгийн шүүхийн шийдвэрээр бурханыг мөнгөн хэлбэрээр төлүүлсэн байна.

Төв аймгийн музей:

- 1997 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хооронд музейн угсаатны зүйн танхимаас хаш хөөрөг алдагдсан байна. Аймгийн Цагдаагийн газраас уг асуудалд эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгасан ч Төв аймгийн Прокурорын газрын 2003 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 92 дугаар хариу мэдэгдэх хуудсаар “хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан тул уг хэргийг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэсэн” байна.
- 1998 оны 05 дугаар сард музейд тайлбарлагч ажилтай П.Чимэдболъ нь музейн үзвэрийн танхимаас мөнгөн тоногтой хэт хутга хулгайлсан гэх асуудалд аймгийн Цагдаагийн хэлтсээс эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгажээ. П.Чимэдболъ нь 400.000 төгрөгийг хувиасаа гаргаж, ижил төстэй хэт хутгыг худалдан авч музейд өгсөн байна. Төв аймгийн сум дундын 1 дүгээр шүүхийн 1999 оны 01 дүгээр сард 25 тоот тогтоолоор “шүүгдэгч хохирлыг бүрэн төлж барагдуулсан” гэж үзээд нэг жилийн тэнсэн харгалзах ял оноож шийдвэрлэсэн байна.
- 2001 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс 11 дүгээр сарын 04-ний өдрийн хооронд музейн угсаатны зүйн танхимаас мөнгөн тоногтой хэт хутга хулгайд алдагдсан байна. Уг асуудалд аймгийн Цагдаагийн газраас эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгасан ч өнөөдрийг хүртэл олдоогүй байна.
- 2003 оны 08 дугаар сарын 20-ны шөнө музейд хулгайч орж хөөрөг, цөгц, гаанс, аяга зэрэг угсаатны зүй, шашны холбогдолтой 22 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг хулгайлсан байна. Аймгийн Цагдаагийн газраас уг асуудалд эрүүгийн 315522 тоот хэрэг үүсгэн мөрдөн шалгаж 5 үзмэр, эд өлгийн зүйлийг хураан авч музейд шилжүүлэн өгсөн байна. Төв аймаг дахь Сум Дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн 2004 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 185 дугаар захирамжаар музейд жижүүрээр ажиллаж байсан Ц.Эрдэнэчимэгийг буруутай гэж үзэн 2.251.000 төгрөгийн хохирлыг музейд нөхөн төлүүлэх шийдвэр гаргажээ. Энэ шийдвэрийн дагуу иргэн Ц.Эрдэнэчимэгээс төлбөрийг бүрэн төлж барагдуулсан байна.

Хөвсгөл аймгийн музей:

- 2000 оны 02 дугаар сарын 28-ны өдөр музейн үзүүллэгийн танхимаас 12 нэр төрлийн үзмэр, эд өлгийн зүйлс хулгайд алдагджээ. Аймгийн Цагдаагийн хэлтсээс 017109 дугаартай эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгаж, гэмт хэрэгт холбогдох этгээдийг баривчилсан байна. Хөвсгөл аймгийн эрүүгийн хэргийн шүүхээс холбогдох этгээдэд хорих ял оноож, хохирлыг барагдуулсан байна.
- 2003 онд музейн сан хөмрөгчөөр ажиллаж байсан С.Сэрээнэндоржид холбогдуулан "музейн үзмэр, эд өлгийн зүйлсийг дутагдуулж, ашигласан" гэх асуудлаар аймгийн Цагдаагийн хэлтсээс эрүүгийн 20419266 дугаартай хэрэг үүсгэн мөрдөн шалгаж, угсаатны зүй, шашны холбогдолтой 31 нэр төрлийн 2.395.796 төгрөгийн үзмэр, эд өлгийн зүйлсийг дутагдуулж, зарж борлуулсан болохыг тогтоосон байна. Гэвч аймгийн Прокурорын газраас "эрүүгийн хариуцлагад татах хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн" гэх шалтгаанаар хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.
- Музейд сан хөмрөгчөөр /фондчин/ ажиллаж байсан З.Алтантуяа нь тус музейд 2005 оны 06 дугаар сараас 2007 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн хооронд ажиллах хугацаандаа угсаатны зүй, шашны холбогдолтой 47 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлсийг дутагдуулж үрэгдүүлсэн гэх асуудлаар Аймгийн Цагдаагийн хэлтсээс эрүүгийн 20710247 дугаартай хэрэг үүсгэн мөрдөн шалгажээ. Хэргийг тодорхой хугацаанд түр түтгэлзүүлээд, аймгийн прокурор А.Аварзэдийн 2012 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн прокурорын даалгавараар сэргээн мөрдөн шалгах ажиллагааг гүйцэтгэж байна. Музейгээс дутагдсан гэх 47 үзмэр, эд өлгийн зүйлс олдоогүй байна.

Дархан-Уул аймгийн музей:

- 2004 оны 05 дугаар сарын 02-ны өдөр тус музейн угсаатны зүйн танхимаас 2 ширхэг мөнгөн хэт хутга, 1 ширхэг Замган гартаам хөөрөг /даалинтай/, 1 ширхэг Чүнчигноров хөөрөг /даалинтай/, 1 ширхэг Манан хөөрөг, 1 ширхэг даалин тус тус хулгайд алдагдсан байна. Энэ хэрэгт аймгийн Цагдаагийн газраас 20423250 тоот эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгасан ч Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн 2005 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 08 тоот тогтоол, Дархан-Уул аймаг дахь Давж заалдах шатны шүүхийн 2005 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 20 тоот магадлангаар хэргийг хаажээ. Хулгайд алдагдсан үзмэр, эд өлгийн зүйл олдоогүй байна.
- 2008 оны 05 дугаар сарын 12-ны шөнө аймгийн музейн үүдэнд байсан 2 ширхэг тээрмийн чулуу хулгайд алдагдсан ч аймгийн Прокурорын газрын 2008 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 18 тоот албан бичгээр "хохирлын хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрэхгүй байх тул гэмт

хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзэн эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн” байна. Тээрмийн чулууд олдоогүй байна.

Өмнөговь аймгийн музей:

- 1998 оны 11 дүгээр сард музейн танхимаас 1 ширхэг сийлбэртэй шүрэн хөөрөг хулгайд алдагдсантай холбогдуулан аймгийн Цагдаагийн хэлтсээс 811189 тоот эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгажээ. Аймгийн Прокурорын газрын 2003 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 357 дугаар мэдэгдэх хуудсаар “хөөн хэлэлцэх хугацаа дууссан тул хэрэгсэхгүй болгож” шийдвэрлэсэн байна. Хулгайд алдагдсан үзмэр, эд өлгийн зүйл олдоогүй байна.
- 2004 оны 11 дүгээр сард музейн үзмэрийн танхимаас 1 ширхэг шүрэн бугуйвч хулгайд алдагдсан байна. Аймгийн Цагдаагийн газраас эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, улсын хэмжээнд эрэн сурвалжилж байгаа ч өнөөдрийг хүртэл олдоогүй байна.

Увс аймгийн музей:

- 1998 оны 01 дүгээр сарын 22-24-ны өдрийн хооронд музейн үзүүлэгийн танхимаас чөмгөн сийлбэр /хүний дунд чөмгөөр хийсэн/ 1 ширхэг үзмэр хулгайд алдагдсан. Хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нь тодорхойгүй, үзмэр, эд өлгийн зүйл олдоогүй байна.
- 2005 оны 05 дугаар сарын 25-ны өдөр музейн угсаатны зүйн танхимын шилэн хоргоноос Тамхины мөнгөн хэрэглэл /ууттайгаа/ 2 ширхэг, Гаансны сэтгүүр 1 ширхэг, Мөнгөн аяга 1 ширхэг нийт 4 ширхэг үзмэр хулгайд алдагдсан байна. Аймгийн Цагдаагийн хэлтсээс эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгаж холбогдох этгээдийг олж тогтоосон ч үзмэр, эд өлгийн зүйлийг олдоогүй байна. Увс аймаг дахь шийдвэр гүйцэтгэх албаны 2008 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн албан бичгээр “Сум дундын шүүхийн 2006 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 487 дугаар захирамж, 09 тоот гүйцэтгэх хуудастай Г.Энхбаяр, Г.Батбаяр нарт холбогдох баримт бичгийг хүлээн авч гүйцэтгэх ажиллагаа явуулж байгаа” тухай музейд мэдэгдсэн ч өнөөдрийг хүртэл хохирлыг барагдуулаагүй байна.

Завхан аймгийн музей:

- 2003 онд үзмэрийн танхимаас алт шармал гуулин Ямандаг бурхан, 2004 онд мөн үзмэрийн танхимаас улаан шүрэн Одогмид бурхан тус тус хулгайд алдагдсан байна. Аймгийн Цагдаагийн хэлтсээс эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгах явцад тус хэрэгт холбогдуулан шалгаж байсан иргэд нас

барсан тул тус аймгийн Шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ. Хулгайд алдагдсан үзмэр, эд өлгийн зүйл олдоогүй байна.

- 2006 оны 02 дугаар сарын 14-ний шөнө гэмт этгүүдүүд музейн харуулын амь насыг хөнөөн 5 ширхэг үзмэрийг хулгайлан үзмэрийн танхимд гал тавьсан байна. Аймгийн Цагдаагийн хэлтсээс эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгаж эзэн холбогдогчийг шуурхай илрүүлэн хулгайлагдсан 5 ширхэг үзмэрийг музейд хүлээлгэн өгчээ.

Говь-Алтай аймгийн музей:

- 2011 оны 01 дугаар сарын 13-ны шөнө музейн үзүүллэгийн танхимаас гууль цутгамал Бурхан багш хулгайд алдагдсан байна. Аймгийн Цагдаагийн хэлтсээс эрүүгийн 21105038 тоот хэрэг үүсгэн мөрдөн шалгасан ч Говь-Алтай аймгийн Прокурорын газрын 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 288 тоот мэдэгдэх хуудсаар "хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн" байна. Хулгайд алдагдсан үзмэр, эд өлгийн зүйл олдоогүй байна.

Эрдэнэ Зуу музей:

- 2014 оны 05 дугаар сарын 18-ны шөнө Эрдэнэ Зуу музейн Гол гурван зуугийн сүмээс Дүйнхор, Жүгдэрнамжил, Майдар Манзушир нэртэй 7 бурхан хулгайд алдагдсан байна. Уг хэрэгт Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсээс эрүүгийн 201415010081 дугаартай хэрэг үүсгэн шалгаж, холбогдох этгээдийг баривчлан, хулгайлагдсан бурхадыг хураан авч музейд хүлээлгэн өгсөн байна. Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 10 дугаар шийтгэх тогтоолоор шүүгдэгчдийг гэм буруутайд тооцон тус бүр 12-13 жилийн ял оноон, 17.825.505 төгрөгийг гаргуулж Эрдэнэ Зуу музейд олгохоор шийдвэрлэжээ. Дээрх шийтгэх тогтоолыг Өвөрхангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 14 дүгээр магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүхийн 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 134 дүгээр тогтоолоор тус тус хэвээр үлдээн шийдвэрлэсэн байна.

Монгол Цэргийн музей:

- 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдөр музейн шинэ түүхийн танхимаас дурсгалын "Зауэр" маркийн гар буу хулгайд алдагдсан. Уг асуудлаар Баянзүрх дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтсээс эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгаж эзэн холбогдогчийг тогтоон баривчилсан ч гар бууг олж

чадаагүй байна. Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 165 тоот тогтоолоор “шүүгдэгчээс 3.900.000 төгрөгийг гаргуулан Монгол Цэргийн музейд олгуулах”-аар шийдвэрлэжээ.

Шанхын Баруун хүрээ хийд:

- Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших Шанхын Баруун хүрээ хийдэд 1993, 1997, 2000, 2002, 2007, 2010 онуудад хулгайч орж бурхан, шашны эд зүйл хулгайлсан байна. Дээрх хэрэгт Хархорин сум дахь Цагдаагийн хэлтсээс тухай бүр эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгаж, эзэн холбогдогчийг тогтоон хулгайлагдсан эд зүйлсийг хийдэд буцаан олгож байжээ. Өнөөдрийн байдлаар тус хийдээс 1993 онд алдагдсан Очирваань, Махгал, Ямандаг бурхад олдоогүй байна.

б) Музейн үзмэр, эд өлгийн зүйлийг гадаадад үзэсгэлэнд оролцуулахаар явуулсан ч эргэж ирээгүй 3 тохиолдол гарсныг 2007, 2012 оны улс орон нутгийн музейн сан хөмрөгт явуулсан тооллогын мэдээнд үндэслэн музей тус бүрээр гаргалаа. Үүнд:

Төв аймгийн музей:

- 1997 онд Аймгийн Засаг даргын Тамгын газраас Япон Улсын Таттори мужид зохион байгуулагдсан “Экспо-97” арга хэмжээнд оролцуулахаар музейн сан хөмрөгөөс 127 нэрийн үзмэр, эд өлгийн зүйлсийг түр хугацаагаар авч явсан ч 6 ханатай иж бүрэн сийлбэртэй гэр зэрэг 19 нэр төрлийн үзмэр, эд өлгийн зүйлс эргэж ирээгүй байна. Аймгийн Засаг даргын Тамгын газраас 2001 онд музейд 4.0 сая төгрөгөөр 2 гэр худалдан авч өгсөн байна. Бусад үзмэр, эд өлгийн зүйлсийн хохирлыг барагдуулсан эсэх нь тодорхойгүй үлджээ.
- 1999 онд аймгийн Засаг даргын Тамгын газраас Бүгд Найрамдах Солонгос Улсын Канвон мужид зохион байгуулагдсан “Экспо-99” арга хэмжээд оролцуулахаар музейн сан хөмрөгөөс 46 нэр төрлийн 176 ширхэг үзмэр эд өлгийн зүйлсийг үзэсгэлэнд оролцуулахаар явч явсан ч эргэж өгөөгүй байна. Энэ асуудлаар 2003 онд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн үйлдсэн 43/02 тоот актыг үндэслэн аймгийн Сум дундын 1 дүгээр шүүхийн 2009 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 149 дүгээр тогтоолоор Төв аймгийн Засаг даргын Тамгын газрыг “музейд 1.067.600 төгрөгийн хохирол учруулсан”-ыг тогтоон, хохирлыг төлж барагдуулахаар шийдвэрлэсэн байна. Энэ шийдвэрийг Төв аймгийн давж заалдах шатны иргэний хэргийн шүүхийн 2003 оны 26 тоот магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүхийн 2003 оны 665 тоот тогтоолоор хэвээр үлдээн шийдвэрлэжээ. 2004 онд Төв аймгийн Засаг

даргын Тамгын газраас шүүхийн шийдвэрийн дагуу музейд учруулсан хохирлыг мөнгөн хэлбэрээр бүрэн төлж барагдуулсан байна.

Увс аймгийн музей:


- 2007 онд иргэн Ц.Батсуурь аймгийн музейгээс 10 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг Япон улсын Ибараки мужид үзэсгэлэнд оролцуулахаар авч яваад 9 ширхэг үзмэрийг буцаан өгч 1 ширхэг үзмэр /Дөрвөд эр тэрлэг /-ийг дутаасан байна. Аймгийн музейгээс 2010 оны 05 дугаар сарын 05-ны өдөр аймгийн Цагдаагийн газарт хандан дутаасан үзмэрийг Ц.Батсууриас гаргуулж өгөхийг хүсэж албан бичиг илгээсэн ч Аймгийн Прокурорын газраас уг асуудалд "эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлгүй байх тул эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн" талаар 2010 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 5/668 дугаартай мэдэгдэх хуудсаар мэдэгджээ. Иргэн Ц.Батсуурь нь Дөрвөд эр тэрлэгийн нөхөн төлбөр болгон 3.000.000 /гурван сая/ төгрөг өгснийг музейгээс дутсан дээлтэй ижил дээл хийлгэн сан хөмрөгт нөхөн бүрдүүлэлт хийсэн байна.

5. Соёлын өвийг хамгаалах тухай хууль батлагдсанаас хойших хугацаанд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийсэн үр дүн, мэдээллийн тухайд;

Соёл, спорт, аялал жуулчлалын яам /хуучин нэрээр/-наас Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дүгээр хэсэгт заасныг хэрэгжүүлэх зорилгоор түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогын ажлыг 2015 онд улс орон даяар зохион байгуулахаар төлөвлөн зохих бэлтгэлийг хангажээ. Үзлэг, тооллогын бэлтгэл ажлын хүрээнд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийн арга зүйг боловсронгуй болгох, программын өгөгдлийг шинэчлэх, үзлэг тооллогын гарын авлагыг бэлтгэж хэвлүүлэх зэрэг ажлыг гүйцэтгэсэн байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас 2015 оны 4 дүгээр сард орон нутагт түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогын ажлыг хариуцан зохион байгуулах 75 мэргэжилтэнд үзлэг, тооллогын талаар сургалт хийн, гарын авлага, дурсгалын бүртгэлийн материалаар хангаж, бүх аймгийн Засаг дарга нарт холбогдох заавар чиглэлийг хүргүүлсэн байна.

2015-2016 онд зохион байгуулсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогод нийт 9.537 дурсгалт газрын 86.157 дурсгал бүртгэгдсэн байна. Үзлэг, тооллогод хамрагдсан нийт дурсгалын 52.2 хувь нь буюу 3.387 дурсгалт газрын 44.977 дурсгал нь шинээр бүртгэгдсэн байна. Дурсгалыг төрөл, бүртгэгдсэн нийт дурсгалд эзлэх хувийг графикаар үзүүлбэл:



Үзлэг, тооллогын ажлын хүрээнд дурсгалыг төрөлжүүлэн бүртгэх, гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулах, зарим дурсгалын хэмжээсийг авах, засаг захиргааны нэр солигдсон дурсгалт газрын нарийг засах, эрсдэлд орсон дурсгалын талаарх мэдээллийг цуглуулж орон нутагт мэдэгдэх, дурсгалын эвдрэл гэмтлийн талаарх мэдээллийг цуглуулах, хамгаалалтын бүс тогтоох шаардлагатай дурсгалд хэмжилт хийх зэрэг ажлыг гүйцэтгэжээ.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогын ажлын бэлтгэлийг хангах, орон нутгийн үзлэг, тооллогын комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Соёл, спорт, аялал жуулчлалын сайд болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын багцаас 64.036.400 төгрөгийг гаргаж орон нутагт шилжүүлсэн бол аймаг, нийслэлийн Засаг даргын багцаас 71.689.300 төгрөгийг гаргаж үзлэг, тооллогын ажилд зарцуулжээ.

6. Соёлын өвийг сэргээн засварлах ажиллагааг эрчимжүүлэх талаар хийгдэж буй ажлын тухай;

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас Соёлын биет өвийг сэргээн засварлах дүрэм журмыг шинэчилж боловсронгуй болгох, техник, тоног төхөөрөмжийн болон хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх, соёлын биет өвийг сэргээн засварлахад зарцуулж буй хөрөнгийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч байна.

Тухайлбал, соёлын биет өвийг сэргээн засварлах дүрэм журмыг шинэчлэх ажлын хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Дэд бүтцийн сайдын 2004 оны 183/111 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Түүх, соёлын дурсгалыг сэргээн

засварлах ажил гүйцэтгэх журам"-ыг Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нийцүүлэн "Соёлын биет өвийг сэргээн засварлах журам", "Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах журам" болгон шинэчлэн боловсруулж байна.

2014 онд Соёл, спорт, аялал жуулчлалын яамны эхлүүлсэн Соёлын өвийн төвийн барилгыг 2018 онд бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Барилга ашиглалтад орсноор соёлын биет өвийн эвдрэл гэмтлийг лабораторийн түвшинд тогтоох, сэргээн засварлах арга технологийг судалгааны үндэслэлтэй боловсруулах, археологи, палеонтологийн олдвор, судалгааны хэрэглэгдэхүүнийг хадгалах болон бэхжүүлэх, сэргээн засварлах байр танхимын хүрэлцээ нэмэгдэх юм.

Соёлын биет өвийг сэргээн засварлах чиглэлээр мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх зорилгоор Бүгд Найрамдах Польш Улсын Варшавын их сургуульд 4 оюутанг соёлын өвийг сэргээн засварлах мэргэжлээр сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулж байна, мөн Япон улсын Нарагийн их сургуульд 2 мэргэжилтэнг мод, металын материал бүтцийн судалгааны чиглэлээр магистр, докторын түвшинд суралцуулж бэлтгээд байна. Одоо тус сургуульд 1 оюутан сургалтын төрийн сангийн зээлээр ханын зургийг хамгаалах, сэргээн засварлах чиглэлээр магистрын түвшинд суралцаж байна.

Соёлын өвийн үндэсний төвийн сэргээн засварлагч судлаачдыг гадаадын өндөр хөгжилтэй орнуудад богино хугацааны сургалтад хамруулах ажлыг жил бүр зохион байгуулж байна. Түүнчлэн, 2015-2017 онд Монаккогийн вант улсын Засгийн газрын санхүүжилтээр ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газартай хамтран Булган аймгийн Баяннуур сумын Шороон бумбагарын бунхант булш, ханын зурагт түшиглэн ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Соёлын өвийн төвийн нийт 9 сэргээн засварлагчийг ханын зургийг хамгаалах сэргээн засварлах богино хугацааны сургалтад хамруулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан "Чулуун соёлын өв" хөтөлбөрийг 2018 оноос эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж зохих бэлтгэлийг хангаж байна. Хөтөлбөрийн хүрээнд чулуун соёлын өвийг бүртгэн баримтжуулах ажлыг эрчимжүүлэх, чулуун соёлын өвийн судалгаа, шинжилгээний ажлыг дэмжих, чулуун соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах, чулуун соёлын өвийг сурталчлах, чулуун соёлын өвийг түшиглэсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох зорилтын хүрээнд 80 гаруй арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

7. Барилгын чанар, аюулгүй байдал, ашиглалтын шаардлага хангахгүй болсон музейн барилгуудыг хэдий хэр хугацаанд шинэчлэн засварлах, шинэчилж

засварлахад шаардлагатай мөнгөн хөрөнгийг улсын болон нийслэлийн төсөвт тусгасан эсэх;

2018 оны 01 дүгээр сарын байдлаар төрийн өмчийн 9 музейн эзэмшилд 27 барилга байгууламж, орон нутгийн өмчийн 19 музейн эзэмшилд 56 барилга байгууламж, нийт 83 барилга байгууламж ашиглагдаж байна. Төрийн өмчийн музейгээс өөрийн байргүй, орон нутгийн өмчийн барилга байгууламжийг түрээслэн үйл ажиллагаа явуулж байгаа 2 музей /Монголын Театрын музей, Монголын Уран зургийн галерей/, төрийн өмчийн барилга байгууламжийг хамтран эзэмших хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа 1 /Төрийн түүхийн музей/ музей байгаа бол, орон нутгийн өмчийн музейгээс өөрийн байргүй, орон нутгийн өмчийн барилга байгууламжийг хамтран эзэмших хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа 5 /Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон, Увс, Хөвсгөл аймгийн музей/ музей байна.

Төрийн өмчийн 9 музейн эзэмшиж байгаа 27 барилга байгууламжийн 4 нь музейн зориулалттай, 16 нь сүм хийд, ордны зориулалттай, 2 нь музейн сан хөмрөг, оффисын зориулалттай, 5 нь орон сууц, агуулах, худалдаа үйлчилгээ, сургуулийн зориулалттай барилга байгууламж байна. Орон нутгийн өмчийн музейн эзэмшиж байгаа 56 барилга байгууламжийн 13 нь музейн зориулалттай 27 нь сүм хийд, ордны зориулалттай, 1 нь музейн сан хөмрөг, оффисын зориулалттай, 15 нь орон сууц, зочид буудал, худалдаа үйлчилгээ, номын сан, гэрэл зургийн студи гэх мэт музейн зориулалтын бус барилга байгууламжид байна. Төрийн болон орон нутгийн өмчийн музейн эзэмшиж байгаа барилга байгууламжийн 21.68 хувь нь музейн зориулалтын, 51.8 хувь нь сүм хийд, ордны зориулалтын, 3.61 хувь нь музейн сан хөмрөг, оффисын зориулалттай, 22.9 хувь нь музейн зориулалтын бус барилга байгууламж байна. /Судалгааг хавсаргав/

Төрийн болон орон нутгийн өмчийн 36 музейн эзэмшиж байгаа барилга байгууламжид Мэргэжлийн хяналтын байгууллагаас хийсэн шалгалтаар Байгалийн түүхийн музей, Хөшөө цайдам музей, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорнод, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Ховд, Хэнтий аймгийн музейн эзэмшиж байгаа 12 барилга байгууламжид үйл ажиллагаа явуулах боломжгүй, 68 барилга байгууламжид их, бага хэмжээний засвар үйлчилгээ хийх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байна. Дээрх музейн барилгаас Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын тушаалаар Байгалийн түүхийн музейн "А" блокт музейн үйл ажиллагаа явуулахыг 2013 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс зогсоож, бусад 11 музей барилга байгууламжийг ашигласаар байна.

Манай Улс 1996 онд Монгол Цэргийн музейн барилгыг улс орон нутгийн төсөв, иргэд олон нийтийн хандиваар барьж ашиглалтад оруулснаас хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинэ музейн барилга баригдаагүй, харин 2010 онд Япон улсын Засгийн газрын тусламжтайгаар

“Хархорум” музейн барилгыг барьж ашиглалтад оруулсан байна. Өмнөговь, Орхон аймгийн музей шинэ барилгын зураг төсөв, газар, техникийн бусад дүгнэлтийг бэлтгэн 10 гаруй жил болж байгаа ч санхүүжилтгүйн улмаас барилгын ажил эхлээгүй байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас ашиглалтын шаардлага хангахгүй байгаа музейн эзэмшлийн барилга байгууламжийг шинээр барих ажлыг Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, бусад бодлогын баримт бичигт нийцүүлэн музейн барилга байшинг шинэчлэх бодит хэрэгцээ шаардлага, бүс нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт музейн цуглуулгын нөөцийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох боломж, улс, орон нутгийн санхүү, төсвийн боломж бололцоо зэргийг харгалзан эрэмбэлж, шат дараатай хэрэгжүүлэхээр төлөвлөн зарим ажлыг эхлүүлээд байна. Энэ ажлын хүрээнд Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Байгалийн түүхийн музейг олон улсын тусламжийн хөрөнгөөр, Баянхонгор, Орхон, Өмнөговь аймгийн музейн барилгыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинэчлэн барихаар тусгаж бэлтгэлийг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 01 дүгээр сард Бүгд Найрамдах Солонгос Улсад хийсэн албан ёсны айлчлалын үер Байгалийн түүхийн музейн шинэ барилга барих төслийг Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх саналыг тус улсын Засгийн газарт дахин тавьсан. Бүгд Найрамдах Солонгос Улсын талаас асуудлыг судалж үзэн хариу өгөхөө мэдэгдээд байна.

2017 онд Баянхонгор, Орхон, Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран шинэ музейн барилгын зураг төсөв, барилга барих газар, техникийн дүгнэлтүүдийг бэлэн болгож, 2018 оны хавраас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Өмнөговь аймгийн музейн шинэ барилгын барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. 2019 онд Өмнөговь аймгийн музейн барилгын ашиглалтад оруулж, Орхон, Баянхонгор аймгийн музейн барилгын барилга угсралтын ажлыг эхлүүлэн 2020 онд ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.

Түүнчлэн, төрийн болон орон нутгийн өмчийн музейгээс ирүүлсэн хүсэлтийг судалж үзээд 2018 оны Төсвийн тухай хуулиар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцад хуваарилагдсан боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын их засварын зардлаас Баян-Өлгий аймгийн музей их засвар, Үлэг гүрвэлийн төв музейн дээврийн засвар, Монголын Үндэсний музейн дээврийн засварт, “Ялалт” музейн гадна, дотор засварт тодорхой хэмжээний хөрөнгийг хуваарилахаар төлөвлөн ажиллаж байна.

Цаашид музейн барилга байгууламжийг шинээр барих, шинэчлэн засварлах ажлыг тухайн музейн төрөл, үйл ажиллагааны онцлогт тохируулан судалгааны үр дүнд үндэслэн боловсруулсан хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан нэгдсэн бодлого төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ялангуяа барилгын өрөө тасалгаанд тохируулсан музейг хөгжүүлэх уламжлалт сэтгэлгээг халж, орчин үеийн дэлхийн музейнүүдийн сайн туршлагыг өөрийн орны онцлогт тохируулж нутагшуулах, музейн барилга байгууламжийг барих шилдэг арга технологийг нэвтрүүлж, үндэсний хэлбэр, зохиомж бүхий музейн барилга байгууламжийн тоог олшруулах нь зүйтэй байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам энэ бодлогын хүрээнд Музейн тухай хууль батлагдсаны дараа музейг хөгжүүлэх үндэсний хэмжээний томоохон хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

8. Соёлын өвийг өвлөн уламжлагчдыг хэрхэн урамшуулж байна, “Соёлын өвийг хамгаалахад идэвх санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам” буюу Засгийн газрын 2017 оны 343 дугаар тогтоолын хэрэгжилтийн тухай;

а) Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Журам батлах тухай” 145 дугаар тогтоолоор “Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох журам”-ыг баталж, мөнгөн шагнал олгоход шаардагдах 100.0 сая төгрөгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхаар шийдвэрлэсэн. Гэвч 2017, 2018 оны улсын төсөвт уг зардал батлагдаагүй болно. Мөн журам батлагдсанаас хойш журмын дагуу мөнгөн шагнал олгуулахаар нэр дэвшүүлсэн иргэн, хамт олон бүлэг хүний баримт бичиг тус яаманд ирээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны “Журам батлах тухай” 195 дугаар тогтоолоор батлагдсан “Шилдэг уран бүтээлч шалгаруулах журам”-ын хүрээнд жил бүр соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нэг хүнийг шалгаруулж “Мөнгөн мод” 3.0 сая төгрөгийн шагналыг гардуулж байна.

б) “Соёлын өвийг хамгаалахад идэвхи, санаачлагатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам” нь Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 343 дугаар тогтоолоор батлагдсан. 2018 оны 02 дугаар сарын 15-ны байдлаар журмын дагуу урамшуулал олгуулахаар нэр дэвшүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагын баримт бичиг тус яаманд ирээгүй болно. Харин Засгийн газрын 2003 оны “Журам батлах тухай” 23 дугаар тогтоолоор баталсан “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг алдаршуулах, урамшуулах журам”-ын хүрээнд түүх, соёлын дурсгалт зүйлийг төрийн өмчид шилжүүлсэн 6 иргэнд /2011 онд 2 иргэн, 2015 онд 1 иргэн, 2017 онд 3 иргэн/ нийт 12.5 сая төгрөгийг урамшууллыг олгосон байна.

9. Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн хадгалалт хамгаалалтыг эрс сайжруулах, зориулалтын барилга, сан хөмрөгтэй болгох, музейн үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх, менежмент, маркетингийг өөрчлөх асуудлыг шийдвэрлэхэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай;

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас 2016 онд шинээр боловсруулж баталсан Эрүүгийн болон Зөрчлийн хуульд анх удаа соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, соёлын өвийг хамгаалах хууль тогтоомжийг зөрчих талаар тусгайлсан бүлэг, зүйлийг тусгаж, соёлын өвийн хадгалалт хамгаалалтын байдалд хохирол учруулсан этгээдэд ногдуулах хариуцлагын хэмжээг чангатгасан.

Музейн барилга байгууламжийн ашиглалтын байдлыг сайжруулах зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн музейн эзэмшиж байгаа улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад орсон сүм хийд, ордны цогцолборыг Засгийн газрын 2007 оны 303 дугаар тогтоолоор баталсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах” хөтөлбөрийн хүрээнд сэргээн засварлах ажлыг үе шаттай хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал 2011-2015 онд Архангай аймгийн музейн Заяын цогцолборыг улсын төсвийн 949.140.427 төгрөгийн хөрөнгө оруулалт болон Монаккогийн Вант улсын Засгийн газрын 100.000.000 төгрөгийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр, 2014-2015 онд Хэнтий аймгийн музейн Цэцэн ханы ордны цогцолборыг улсын төсвийн 584.641.945 төгрөгийн хөрөнгө оруулалтаар сэргээн засварласан, 2013-2015 онд Богд хааны ордон музейн Хувцасны сан, Махранзын сүм, Өвлийн ордныг улсын төсвийн 532.525.416 төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэсэгчлэн сэргээн засварлаж үзмэр, эд өлгийн зүйлийн хадгалалт хамгаалалтын орчин нөхцлийг сайжруулаад байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.48.2-т заасан “Улсын болон орон нутгийн 10 музейг стандартын шаардлага хангасан сан хөмрөгтэй болгох” зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монголын Үндэсний музейн 3 сан хөмрөг, Баян-Өлгий аймгийн музейн 4 сан хөмрөг, Сэлэнгэ аймгийн музейн 3 сан хөмрөгийг стандартын шаардлагад нийцүүлэн засварлаж, шаардлагатай тоног төхөөрөмж суурилуулах арга хэмжээн 2018 эхлүүлэхээр бэлтгэж байна.

Тус яам Музейн үзмэр, эд өлгийн зүйлсийн ашиглалтын байдлыг хэт их хязгаарласан, хориглосон дүрэм, журмын зохицуулалтыг багасган, музей цуглуулгын нөөцийг зохистой хэлбэрээр удирдан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох санаачлагыг дэмжих бодлого барьж ажилласан. Энэ бодлогын үр дүнд Богд хааны ордон музейн дэргэдэх Хаан туульсийн өргөөнд тууль хайлах, Чойжин ламын сүм музейн “Шөнийн музей” арга хэмжээ, Дүрслэх урлагийн музейн буддын шашны дүрслэх урлагийн бүтээл урлах арга ухааныг бодит үзмэртэй хослуулсан цуврал үзэсгэлэн зэрэг цөөнгүй арга хэмжээг бий болоод байна.

Хэдийгээр музейн салбарт гарч буй ололт амжилт жил ирэх тусам өсөн нэмэгдэж байгаа ч үйл ажиллагааны зардал, ажилчдын цалин хөлс, нийгмийн асуудлыг шийдвэрлэх хөрөнгө бага, барилга байгууламжийн ашиглалтын байдал хангалтгүй, хүний нөөцийн чадавхи сул, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт удаан, үйл ажиллагаанаас олсон орлогыг зарцуулах эрх зүйн орчин бүрдээгүй зэрэг хүчин зүйлээс болж музейн хөгжил доривтой өсөхгүй байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас музейн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, музейн үйл ажиллагаанд тавигдах стандарт шаардлагыг шинэчлэх, музейг өөрийн орны онцлог, цуглуулгын нөөцөд тулгуурлан төрөлжүүлэх, музейн барилга байгууламжийг шинэчлэх, музейн мэргэжлийн боловсон хүчнийг мэргэшүүлэх, давтан сургах, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, санхүү, эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлэн үе шаттай хэрэгжүүлж, музейн нийгэмд гүйцэтгэх үүрэг, үнэлэмжийн нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн музейн барилга, байгууламжийн судалгаа

Д/д	Музейн нэр	Барилга байгууламжийн тоо	Ашиглалтад орсон он	Зориулалт	Өмчийн хэлбэр	Тайлбар
1. Төрийн өмчийн музей						
1	Монголын Үндэсний музей	1	1971	Музей	Төрийн өмч	Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны харьяанд
2	Байгалийн түүхийн музей	3	а. Блок 1956	Хөдөө аж ахуйн техникум	Төрийн өмч	Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны харьяанд
			б. Блок 1967		Төрийн өмч	
3	Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей	1	1905	Худалдаа үйлчилгээний зориулалттай	Төрийн өмч	Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны харьяанд
					Төрийн өмч	
4	Богд хааны ордон музей	8	Махранзын сум, Номын Найдан сум, Номын сан, Лаврин зэрэг сум болон Өвлийн ордонг 1893-1905	Ордны цогцолбор	Төрийн өмч	Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны харьяанд
			Сан хөмрөгийн барилгыг 2010		Төрийн өмч	
5	Чойжин ламын сум музей	9	Махранзын сум, Гол сум, Зуугийн сум, Занхан сум, Ядамын сум зэрэг цогцолборыг 1904-2009	Сүмийн цогцолбор	Төрийн өмч	Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны харьяанд
6	Монголын Театрын музей		1987	Соёлын төв өргөөний "" корпусын 589,5 м ² талбай	Нийслэлийн өмч Түрээс	Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны харьяанд
7	"Хархорум" музей	1	2010	Музей	Төрийн өмч	Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны харьяанд
8	"Хөшөө цайдам" музей	1	2010	Агуулах	Төрийн өмч	Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны харьяанд
9	Үлэг гүрвэлийн төв музей	1	1980	Музей	Төрийн өмч	Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны харьяанд
10	Монголын Уран зургийн галерей		1987	Соёлын төв өргөөний "Б" корпусын 2500 м ² талбай	Нийслэлийн өмч Түрээс	Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны харьяанд
			1996	Музей	Төрийн өмч	
11	Монгол Цэргийн музей	2	1937	Орон сууц	Төрийн өмч	Батлан хамгаалах яамны харьяанд
			2008	Төрийн хүндэтгэлийн цогцолборын зоорийн	Төрийн өмч	
12	Төрийн түүхийн музей					Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяанд

		давхар				
2. Орон нутгийн өмчийн музей						
13	Улаанбаатар хотын музей	1	1918	Орон сууц	Төрийн өмч /Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал/	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын харьяанд
14	"Эрдэнэзуу" музей	19	Глд 3 зуу, Далай ламын сум, Рэгсүнгомбын сум, хэрмийн 4 асар хаалга зэрэг 18 сум дуганыг 1586-1826 1975	Сүм хийд Сан хөмрөг	Орон нутгийн өмч /Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал/	Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд
15	Архангай аймгийн музей	4	Гүдэн 1696 Баруун сэмчин 1802 Зүүн сэмчин 1802	Сүм, хийд	Орон нутгийн өмч /Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал/	Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд
16	Баян-Өлгий аймгийн музей	1	Махранзын сүм 1802 1988	Музей	Орон нутгийн өмч	Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд
17	Баянхонгор аймгийн түүх, угсаатны зүйн музей	2	Түүх, угсаатны зүйн музей 1971 Байгалийн түүхийн музей 1978	Цэнгэлдэх хүрээлэн Сургуулийн хичээлийн байр	Орон нутгийн өмч Орон нутгийн өмч	Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд
18	Булган аймгийн музей	3	Төв музей 1960 Штаб музей 1870 Магсаржавын дуулгат бунхан 1970	Музей Орон сууц Бунхан	Орон нутгийн өмч	Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд
19	Говь-Алтай аймгийн музей	1	1957	Орон нутаг судлах музей	Орон нутгийн өмч	Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд
20	Говьсүмбэр аймгийн музей	Музей номын сан хамт		Номын сан	Орон нутгийн өмч	Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд
21	Дархан-Уул аймгийн музей	Үйлчилгээний төвийн цогцолбор	1969	Худалдаа үйлчилгээний барилгын 510 м² талбай	Орон нутгийн өмч	Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд
22	Дорнод аймгийн музей	3	Төв музей 1948 Жуковын байр 1938 Байгалийн музей 1955	Орон сууц Сургуулийн хичээлийн байр	Орон нутгийн өмч Орон нутгийн өмч Орон нутгийн өмч	Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд
23	Дорноговь аймгийн музей, сургалт сурталчилгааны төв	1	1974	Орон нутаг судлах музей	Орон нутгийн өмч	Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд
24	Дундговь аймгийн музей	1	1949	Орон нутаг судлах музей	Орон нутгийн өмч	Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд
25	Завхан аймгийн музей	2	Орон нутгийн музей 1973 Алдартны музей 1959	Орон нутаг судлах музей Гэрэл зургийн студий	Орон нутгийн өмч Орон нутгийн өмч	Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд
26	Орхон аймгийн музей	Орон сууц, кино театр,	1979	Кино театрын хонгил	Орон нутгийн өмч	Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд

		Үйлчилгээний байгууллагын коридорын хэсэг										
27	Өвөрхангай аймгийн музей	2	Төв музей 1957 Занабазарын музей 1978	Орон нутаг судлах музей Музей	Орон нутгийн өмч Орон нутгийн өмч				Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд			
28	Өмнөговь аймгийн музей	3	Төв музей 1954 Байгалийн музей 1987 Тэмээний музей 1975	Зочид буудал, 1969 онд 2 давхар болгосон Музей Тэмээний үзэсгэлэн	Орон нутгийн өмч Орон нутгийн өмч Орон нутгийн өмч				Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд			
29	Сүхбаатар аймгийн угсаатны зүйн музей	1	1992	Номын сан	Орон нутгийн өмч				Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд			
30	Сэлэнгэ аймгийн нэгдсэн музей	1	1971	Музей, үзэсгэлэн	Орон нутгийн өмч				Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд			
31	Төв аймгийн музей	1	1962	Орон нутаг судлах музей	Орон нутгийн өмч				Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд			
32	Увс аймгийн музей	Музей, номын сан хамт	Төв музей 1990 Цэдэнбалын музей 2006	Номын сангийн 2 давхрын 361,5 м ² талбай Музей, үзэсгэлэн /өргөтгөл/	Орон нутгийн өмч Орон нутгийн өмч				Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд			
33	Ховд аймгийн музей	1	1961	Орон нутаг судлах музей	Орон нутгийн өмч				Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд			
34	Хөвсгөл аймгийн Орон нутаг судлах музей	Музей, номын сан хамт	2009	Музей, номын сан	Орон нутгийн өмч				Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд			
35	Хэнтий аймгийн музей	6	Гадаад сан, баруун зүүн дотоод сан, Бага яамны сум, Цэдэвчойжин сүмийг 1691-1928	Ордны цогцолбор	Орон нутгийн өмч /Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал/				Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд			
36	"Ялалт" музей	1	Орон нутгийн музей 1945 1984	Орон нутаг судлах музей Музей	Орон нутгийн өмч Орон нутгийн өмч				Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяанд			
	Дүн	83										



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 04 өдөр

Дураар 1/244

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Унгар Улсын иргэн Ласло Кадараас хүлээлгэн өгсөн Занабазар хийцийн гэх Аюуш бурханы онцлог шинж, ур хийцийг тодорхойлон тогтоох, музейн сан хөмрөгт шилжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Гантөмөр /Соёлын бодлого зохицуулалтын газрын даргын үүрэг гүйцэтгэгч/
Гишүүд: С.Урантөгс /Соёлын өвийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч/
Г.Энхбат /Соёлын өвийн төвийн захирал/
Д.Нарантуяа /Соёлын өвийн төвийн биет соёлын өвийг хамгаалах хэлтсийн дарга/
Б.Баярбат /Эрүүгийн цагдаагийн газрын ТСДЗүйл хариуцсан ахлах төлөөлөгч хошууч/
С.Бадрал /Соёл, урлагийн их сургуулийн багш, урлаг судлаач/
Г.Пүрэвбат /Бурхан урлаач лам/
А.Алтангэрэл /Эртний эдлэл цуглуулагчдын холбооны тэргүүн/
Нарийн бичгийн дарга: Ч.Нацагням /Соёлын өвийн хэлтсийн мэргэжилтэн/

1. Энэ тушаалын нэгдүгээрт заасан ажлыг 2015 оны 07 дугаар сарын 05-ны дотор зохион байгуулж үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч/Д.Гантөмөр/-д даалгасугай.

Л.ГАНТӨМӨР

• 09 00863



ДҮРСЛЭХ УРЛАГИЙН МУЗЕЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 9 сарын 22 өдөр


Дугаар 92

Улаанбаатар хот

Үзмэр, эд өлгийн зүйлийг сан хөмрөгт
авах тухай

БСШУСайдын 2015 оны 4-р сарын 24-ны өдрийн А/247 тоот тушаал, 2015 оны 7-р сарын 2-ны өдрийн "Аюуш" бурханыг тодорхойлох ажлын хэсгийн хурлын тэмдэглэл"-ийн шийдвэрийг үндэслэн **ТУШААХ НЬ:**

1. Унгар улсын иргэн Ласло Кадараас хүлээлгэн өгсөн Г.Занабазарын мутрын "Аюуш" бурханыг Дүрслэх урлагийн музейн сан хөмрөгт авсугай.
2. Эд өлгийн зүйлд бүртгэлийн дугаар өгч, зохих ёсны бүртгэл баримтжуулалт хийхийг БМСанч Т.Энхжаргалд даалагсугай.
3. Эд өлгийн зүйлд хувийн дугаар бэхлэж, хадгалалтын нөхцөл бүрдүүлэн, хатуу эдлэлийн сан хөмрөгт хадгалахыг сан хөмрөгч Д.Уранчимэгт даалгасугай.



У.САРАНТУЯА

ДНМ 2015.1.1



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 9 дүгээр сарын 28-ны
өдөр

Улаанбаатар хот

**Дугаар 390
ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.2, 8.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

"Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт батлах тухай" Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 241 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулга бүхий 777 дахь заалт нэмсүгэй:

"777.

Дурсгалын нэр: АЮУШ (ЦАГЛАШГҮЙ ГЭРЭЛТ)

Бүтээлч: Г.Занабазар Холбогдох он цаг: ХҮИ зуун Хадгалагдаж буй газар: Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей

Дурсгалын шинж байдал: Хүрэл цутгамал, алт шармал, жин 2040 гр, өндөр 19,6 см, суурийн диаметр 12,3 см, шармал өнгө бага зэрэг халцарсан, бумба бага зэрэг хазайсан, суурь хэсэгт Нацагдорж товойлгож шармалдсан.

Хувийн дугаар: ДУМ2015.0.01"

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Боловсрол, соёл, шинжлэх

ухааны сайд

Л.ГАНТӨМӨР

Музейн нэр: Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урпагийн музей

САН ХӨМРӨГЧИД ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН АКТ

№01

2015 он 9 сар 28 өдөр

Хүлээлгэн өгсөн: Хужаа овог Цэрэнбямба нэр ЭША /арга-зүйн албаны дарга
(Албан тушаал)

дараах эд өлгийн зүйлийг хариуцахаар хүлээн авсан:
Сан хөмрөгч Доржсүрэн овогтой Уранчимэг нэр сан хөмрөгч

№	Бүртгэлийн дэвтрийн дэсийн дугаар	Бүртгэлийн дэвтэрт бүртгэгдсэн дэсийн дугаар	Эд зүйлийн хувийн дугаар	Тоо ширхэг	Эд зүйлийн нэр	Тайлбар
1	1125DVM0017	9772	ДҮМ2015.1.1	1	Аюуш, цутгуур	
				1		

дэсийн 1 ширхэг хувийн дугаартай 1 ширхэг эд өлгийн зүйлийг
(Тоо, үсгээр)

Музейн захирлын 2015 оны 9-р сарын 28-ны өдрийн 92-р тоот тушаалаар хүлээн авсан талын хариуцлагад хүлээлгэн өгч, хүлээн авав.

Актыг 2 хувь үйлдэж, хариуцсан сан хөмрөгчид, бүртгэл-мэдээллийн санд тус тус хадгална. Хавсралт бүртгэлийн хамт хүчинтэй.

Хүлээлгэн өгсөн албаны дарга:

Хүлээн авсан сан хөмрөгч:

Бүртгэл-мэдээллийн санч:

(Тамга) Захирагч:


Огноо:

..... / Х.Цэрэнбямба /

..... / Д.Уранчимэг /

..... / Т.Энхжаргал /

..... / У.Сарантуяа /



Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын
2012 оны 06 дугаар сарын 25 ны өдрийн
А/355 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

ББЗМаягт 3

Музейн нэр: *Дун*

МУЗЕЙД САНАЛ БОЛГОСОН ЭД ӨЛГИЙН ЗҮЙЛИЙН АКТ

№ *Г.Занабазарын хийгэ.!*

1. Эд өлгийн зүйлийн нэр, онцлог: *Аюуш "Урал уугуур" алт шармаг, хайр агсан*
2. Тоо ширхэг (тоо, үсгээр): *1 (нэг)*
3. Материал, арга техник, хэмжээ: *2040 г. 2040 г. Өч-19,5см, уунд 24-19,3см*
4. Хадгалалтын байдал, гэмтэл: *Тана бүрэн шажал хангаарсан. Зүүнчүүс бүрэн өрөөлөгдсөн, буцаж хэвэртэй, буцаж хэвэртэй*
5. Хадгалах хугацаа: *7р*

Хавсаргасан *1* нийт хуудас жагсаалт *14* гэрэл зураг, бусад *а. Уул буурч алгаарсан.*
(Тоо, үсгээр)

Музей эд өлгийн зүйлийн бүрэн бүтэн байдлыг *2015* оны *06* сарын *15* өдрөөс
..... оны сарын өдөр хүртэл хариуцна.

Актыг 3% үйлдэж, бүртгэл-мэдээллийн сан, өмчлөгч/эзэмшигчид тус тус өгөв.

Эд өлгийн зүйл түр хүлээлгэж өгсөн: *Д.Сүхбаатар Я.Толмогор* /
Холбоо барих утас, хаяг: *БСМУУ-ийн*

Музейд төлөөлөгчөөр хүлээж авсан: *Шариф* / *У.Сүхбаатар* /
(Овог нэр, албан тушаал)

Бүртгэл-мэдээллийн санч: *Т.Толмогор* / *У.Сүхбаатар* / *Уралын*

(тамга) Захирал: *Шариф* / *У.Сүхбаатар* /
Огноо: *2015.06.15*

Үзвэр эзэн зөвлөлийн хурлын шийдвэр ба үндэслэл:
.....

Музейг төлөөлөн эд өлгийн зүйлийг буцааж өгсөн:
.....

(Овог нэр, албан тушаал)

Бүртгэл-мэдээллийн санч: /

Эд өлгийн зүйлийг бүрэн бүтэн хүлээн авсан:
..... /

..... /

(тамга) Захирал: /

Огноо:

МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ

УБМС-ийн дугаар: 1125ДҮМ 03599

Өмчлөгч: Монгол Улс	РД:
Эзэмшигч: Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх Урлагийн музей	РД: 9081542

Дурсгалын оршин байгаа хаяг: 15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жуулчны гудамж 38
Ашиглалтын байдал: Сан хөмрөг 108

Дурсгалын нэр: Аюуш	Хувийн дугаар: ДҮМ2015.1.1
Орон нутаг, олон улс(шинжлэх ухаан)-ын нэр: М: Насан цаглашгүй, Т: Цэвэгмэд, С: Амитаюус, А: Amitayus	

Эх бүтээл Хуулбар





Зэрэглэл: Хосгүй үнэт	Шийдвэр:
-----------------------	----------

Бүртгэлийн ангилал: Ерөнхий бүртгэл
Төрөл зүйл: Шашин шүтлэг->Цутгамал
Он цаг: Манжийн ноёрхлын үе / 1691 - 1911 он / -> ХҮII зууны сүүл, ХҮIII зууны эхэн үе,
Бүтээлчийн нэр ба сургууль хийц: Г.Занабазар (1635-1723)
Материал: Хүрэл, алт, шороон будаг

Хэмжээ	Өндөр (см)	Өргөн(зузаан) (см)	урт (см)	Голч (см)	жин (гр)
	19.5	0	0	12.3	2040

Бурхны хэмжээ: 9.1x13.9x5.3см. Бумба өн-1.8см, дм-5.3см. Сэнтийн дээд хүрээний дм-9.7см.

Гэрэл зураг: 11 ширхэг зурагтай

			
өмнө тал	ар тал	хажуу тал	бусад

Иж бүрдэл: "1"	Тоо ширхэг: 1
----------------	---------------

Зориулалт: Анх шүтээний зориулалтаар бүтээсэн. Одоо музейн үзмэрийн зориулалтаар музейн 108 тоот сан хөмрөгт хадгалагдаж байна.

Ховор түгээмэл байдал: Занабазарын мутрын бүтээл буюу нэн ховор.

Товч түүх: 2015 онд Унгар улсад Өндөр гэгээн Г.Занабазарын 380 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал болсон. Энэ үеэр 50 жилийн өмнө Монгол улсад элчингээр ажиллаж байсан, Унгар улсын иргэн Ласло Кадар Монголоос авчирсан бурхныг нутагт нь эргүүлэн өгөхийг Гандантэгчинлэн хийдийн шашны сургуулийг төлөөлж, хуралд оролцсон Б.Тулгад хүсэлт тавьсан. 2015 онд Монгол Улсын Засгийн газарт албан ёсоор хүлээлгэн өгсөн.